МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

МОНГОЛЫН НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА – 2021



УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

АГУУЛГА

1. НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА 5

1.1. Анхан шатны боловсруулах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт 5

1.2. Хялгас ялгах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт 5

1.3. Ээрэх, будах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт 6

1.4. Хивсний үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт 6

1.5. Эсгий, ноосон дулаалга, бордооны үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт 7

1.6. Нэхэх, сүлжих үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт 7

2. МОНГОЛЫН НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ 9

3. НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД 10

4. НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН БҮТЭЦ 11

5. НООСОН ТҮҮХИЙ ЭДИЙН НӨӨЦ 11

6. НООСОН ТҮҮХИЙ ЭДИЙН БЭЛТГЭЛ 15

7. НООСОН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ 18

8. НООСНЫ УРАМШУУЛЛЫН ҮР ДҮН 22

9. НООСНЫ САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 24

10. НООСОН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН СУУРИЛАГДСАН ХҮЧ ЧАДАЛ БА АШИГЛАЛТ 26

11. НООСОН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ 28

11.1. Хонины ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Урамшууллын падаанаар бэлтгэсэн/ 29

11.2. Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Урамшууллын падаанаар бэлтгэсэн/ 31

12. НООСОН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЭКСПОРТ . 32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 5.1. Малын тоо, төрлөөр, 1930-2021 он, мян.толгой 12
Хүснэгт 5.2. Хонины тоо 2017-2021 он, мян.толгой 13
Хүснэгт 5.3. Тэмээний тоо 2017-2021 он, мян.толгой 14
Хүснэгт 5.4. Хонь, тэмээний тоо 2016-2021 он, мян.толгой 15
Хүснэгт 6.1. 2021 оны ноос бэлтгэлийн тооцоо 16
Хүснэгт 6.2. Хонины ноос бэлтгэлийн хэмжээ 2011-2021 он 17
Хүснэгт 6.3. Тэмээний ноос бэлтгэлийн хэмжээ 2011-2021 он 17
Хүснэгт 7.1. БНХАУ-ын ноосны үнэ, (RMB/кг) 20
Хүснэгт 7.2. Хонь, тэмээний ноосны үнэ, төг 22
Хүснэгт 8.1. Ноосны урамшууллын хэрэгжилт, 2011-2021 22
Хүснэгт 9.1. Ноосны үйлдвэрлэлийн салбарын 2021 оны хөрөнгө оруулалт 25
Хүснэгт 10.1. Ноос боловсруулах үйлдвэрлэлийн салбарын суурилагдсан хүч чадал 26
Хүснэгт 11.1. Ноос боловсруулах салбарын үйлдвэрлэл 28
Хүснэгт 11.2. Ноос боловсруулах салбарын үйлдвэрлэл, (Үйлдвэрлэлийн мэдээгээр) 29
Хүснэгт 11.3. Хонины ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, (Урамшууллын падаанаар бэлтгэсэн) 30
Хүснэгт 11.4. Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, (Урамшууллын падаанаар бэлтгэсэн) 31
Хүснэгт 12.1. Хонь, тэмээний ноосны 2021 оны экспорт, импорт мян.ам.доллар 32
Хүснэгт 12.3. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын экспорт, мян.ам.доллар 32
Хүснэгт 12.4. Хонь, тэмээний ноосон бүтээгдэхүүний экспорт, (Үйлдвэрлэлийн мэдээгээр) 33
Хүснэгт 12.5. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын экспорт, импорт, 2019-2021 он, мян.ам.доллар 35

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 3.1. Ноос боловсруулах үйлдвэрлэлийн салбарт төрөөс баримтлах бодлого 10
Зураг 4.1. Ноос боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бүтэц 11

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 5.1. Нийт малын тоонд малын төрөл тус бүрийн эзлэх хувийн жин, 1970-2021 он 12
График 5.2. Аймаг болон бүсүүдийн хонины тоо, мян.толгой 13
График 6.1. Хонины ноос ашиглалтын харьцаа, мян.тн 17
График 6.2. Тэмээний ноос ашиглалтын харьцаа, мян.тн 18
График 7.1. Дэлхийн ноосны үнэ 2021 оны төгсгөлтэй харьцуулахад 2020 оны төгсгөл (% өөрчлөлт) 18
График 7.2. Нэхмэлийн ширхэгтийн үнийн чиг хандлага, долларын индекс: 2020 оны 1-р сар=100 19
График 7.3. БНХАУ-ын ноосны дээд үнэ, улирлын дунджаар 21
График 7.4. Дэлхийн ноосны үйлдвэрлэл, төрлөөр 21

График 8.1. Монгол улсын нийт бэлтгэсэн ноос ба урамшууллаар бэлтгэсэн ноосны харьцуулалт, мян.тн 23
График 8.2. Монгол улсын нийт малчны тоо ба урамшуулалд хамрагдсан малчны тоо, н.тн .. 23
График 8.3. Урамшууллаар бэлтгэсэн ноосны хэмжээ, аймгаар, 2016-2020 он, мян.тн 24
График 10.1. Угаах үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал 26
График 10.2. Хялгас ялгах үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал 26
График 10.3. Ээрэх үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал 27
График 10.4. Нэхэх үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал 27
График 10.5. Оймс сүлжих үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал 27
График 10.6. Сүлжих үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал 27
График 10.7. Салбарын суурилагдсан хүч чадал ба хүч чадал ашиглалтын харьцаа 28
График 10.8. Салбарын суурилагдсан хүч чадал ба хүч чадал ашиглалтын харьцаа 28
График 11.1. Хонины ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Урамшууллын падаанаар/ 30
График 11.2. Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Урамшууллын падаанаар/ 31

1. НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1. Анхан шатны боловсруулах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Хөдөө орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн түүхий эд бэлтгэх, түүхий эд бэлтгэлийн өртөг зардлыг бууруулах, анхан шатны боловсруулалт хийгдээгүй малын гаралтай түүхий эдийг нийслэл хотод боловсруулахыг зогсоох зорилтыг холбооноос тавьж Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байсан угаах үйлдвэрүүдийг орон нутаг руу нүүлгэн шилжүүлж мөн орон нутагт шинээр үйлдвэрүүд ашиглалтанд орсноор 13 аймагт ноос угаах 14 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй угаах үйлдвэрүүдэд Монгол Улсаас жилд бэлтгэгдэж байгаа нийт ноосон түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх хүчин чадал суурилагдаж улирлын чанартай 500-600 ажлын байрыг орон нутагт шинээр бий болгосон. Эдгээр 14 үйлдвэрээс 5 үйлдвэрийг нь Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлсэн бөгөөд 9 үйлдвэрийг шинээр байгуулахад нийт 23,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт оруулсан байна.

Улаанбаатар хотоос ноос угаах үйлдэрүүдийг орон нутаг руу нүүлгэн шилжүүлж мөн шинэ угаах үйлдвэрүүдийг орон нутагт байгуулж байгаа нь “Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ноос боловсруулах анхан шатны үйлдвэрүүдийг хотын төвлөрсөн хэсгээс гаргах тухай” Монгол Улсын Засгийн Газрын бодлого шийдвэр болон малын гаралтай анхан шатны боловсруулалт хийгдээгүй ноосон түүхий эдийг Улаанбаатар хотод оруулахгүй байх тухай “Ноос боловсруулах үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг Даргын 2015 оны А/230 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээн дэх Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн ачааллыг бууруулах зорилттой нь уялдаж байна.

1.2. Хялгас ялгах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Монгол хонины ноос, тэмээний ноос, сарлагийн хөөврөөс ноолуур үсийг ялгах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж самнах үйлдвэрүүд хүчин чадлаа нэмэгдүүлж мөн шинээр самнах үйлдвэрүүд ашиглалтанд орж эхэлснээр хялгас ялгах хүчин чадал 2012-2020 онуудад 5,9 дахин нэмэгдсэн байна.

Хялгас ялгах хүчин чадал нэмэгдэж эхэлснээр үйлдвэрлэгчид самнасан ноос, хөөврийг экспортод гаргах улмаар нарийн ээрмэл, сүлжмэл, нэхмэл, ноосон оёмол зэрэг шинэ экспортын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдэж байна.

Самнах үйлдвэрүүд ашиглалтанд орж эхэлснээр жилийн 4 улиралд тогтмол байнгын ажиллагаатай үйлдвэрүүдийн тоо нэмэгдэж эдгээр үйлдвэрүүд нийт 300-400 ажлын байрыг шинээр бий болгож, 2012-2019 онуудад хялгас ялгах үйлдвэрлэлд дотоод гадаад эх үүсвэрээс нийт 109 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орсон байна.

Гэвч гадаад дотоод зах зээлийн эрэлтээс хамаарч самнах үйлдвэрүүд суурилагдсан хүчин чадлынхаа 30%-ийг ашиглаж байгаа нь учир дутагдалтай байна. Үүнд дараах шалтгаан нөлөөлж байна.

а) Гадны хөрөнгө оруулалттай угаах үйлдвэрүүд түүхий эдийг угаагаад гаргаж байна.

b) Түүхий эдийн зах зээлийг хамгаалах, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчин хангалтгүй
c) Гадаад дотоод зах зээл дэх ноосон бүтээгдэхүүний борлуулалт хангалтгүй

Цаашид төрөл бүрийн зориулалтаар ашиглагдах самнасан ноосны болон бүсад нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор ноос боловсруулах салбарын үйлдвэрлэлд одоо мөрдөгдөж байгаа хонь тэмээний ноос, сарлагийн хөөврөн бүтээгдэхүүний зарим стандартыг шинэчлэх, шаардлагатай байгаа стандартыг шинээр боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбооноос 2020 онд байгуулан ажиллаж байна.

1.3. Ээрэх, будах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Манай улс зах зээлээс өмнөх нийгэмд 24/2 хүртэл номерын утас үйлдвэрлэдэг байсан бол УИХ-ын 30-р тогтоолын хэрэгжилтийн үр дүнд ээрэх үйлдвэрүүд техник технологийн шинэчлэлт хийж сүлжмэлийн зориулалттай 26/2-48/2, нэхмэлийн зориулалттай 18/1-80/3 номерын утас үйлдвэрлэх хүчин чадал шинээр суурилуулж манай орны ээрмэлийн үйлдвэрлэл дэлхийн зах зээлийн өнөөгийн шаардлагын түвшинд хүрсэн.

Ээрэх үйлдвэрлэлд 108 ажлын байр шинээр бий болж, 16 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Нарийн ээрэхийн техник, технологи, химийн инженерийн багийг бүрдүүлж энэхүү технологийг Монгол Улсдаа нутагшуулсан нь ноос боловсруулах салбарт гарч буй томоохон ололт амжилтын нэг юм.

Олон улсын чанар стандартын шаардлага хангасан будах цехүүдийг шинээр ашиглалтанд оруулснаар хэрэглэгч захиалагчдын хүссэн өнгөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлж байна.

1.4. Хивсний үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Монгол Улсын хэмжээнд өнөөгийн байдлаар 1,950.0 мян.м² хивс үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан боловч гадаад дотоод зах зээл дэх борлуулалтаас хамаарч хүчин чадлын 50% нь ашиглагдаж байна. Урамшууллын бодлого хэрэгжих хугацаанд түүхий эдийн чанар сайжирснаар 8-12 өнгөөр нэхдэг хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн дэлхийн жишигт нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнд:

- Бельги улсын Van de wiele фирмийн UCI03 маркийн 5м өргөнтэй, 1м²-д 1,0-1,2 сая үслэг гогцоотой, өндөр нягттай, дээд зэргийн чанартай хивс үйлдвэрлэдэг нэхэх машиныг Азийн орнуудаас анх удаа Монгол Улсад суурилуулсан.
- Хивс нэхэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Герман Улсад үйлдвэрлэсэн нягтаас нь хамааран 1 цагт 9,6-16 м² хивс нэхэх өндөр хүчин чадалтай ALPHA-300 маркийн машиныг Монгол Улсад анх удаа суурилуулснаар хөдөлмөрийн бүтээмжийг 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтой болсон.
- Хивсний үйлдвэрлэлд Францын Шлюмберже компанид үйлдвэрлэсэн хамгийн сүүлийн үеийн автомат тохиргоотой ERA маркийн нарийн зүүт самнах машиныг шинээр суурилуулан ашиглалтанд оруулснаар ноосны бөл цөл, жигд бус, хогт хольц, богино ширхэгтийн хэмжээ багасч, жигдлэг сайн чанарын ээрмэл үйлдвэрлэх боломжтой болсон.

- Хивсний үндсэн сүлжээний бөхөлгөөг бүрдүүлдэг импортын олсон ба хөвөн утасны оронд дотоодод үйлдвэрлэсэн ноосон үслэг утсыг ашиглаж, 100% цэвэр ноосон хивс гэдгээрээ хэрэглэгчдийн сонирхлыг ихээр татсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой болсон.
- Монголдоо хамгийн өндөр нягтралтай 1м²-д 680,000 ширхэг хатгаштай Улаанбаатар нэр төрлийн хивсийг чанартай нарийн утсаар дахин үйлдвэрлэж эхэлсэн.
- Түрк улсын Ентема компанид үйлдвэрлэсэн SMELL SOFT маркийн очёс /сэв үс/ цэвэрлэх машиныг хивсний үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг өсгөх боломжтой болсон.

1.5. Эсгий, ноосон дулаалга, бордооны үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Монгол Улсын хэмжээнд нойтон аргаар үйлдвэрлэл явуулдаг 120 эсгийний үйлдвэр, хуурай аргын шивэх технологитой 1 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. УИХ-ын 2011 оны 30-р тогтоол гарч ноос бэлтгэн авах боломж бүрдсэнээр хөдөө орон нутагт 70 гаруй эсгий, эсгий эдлэлийн жижиг үйлдвэр шинээр ашиглалтанд орсон нь орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж ажилгүйдлийг бууруулах, өртөг багатай, чанартай бүтээгдэхүүнээр орон нутгийн хэрэглэгчдийг хангахад хувь нэмрээ оруулж байна.

Ноос, бодын хөөвөр, хонь тэмээ ямааны хялгас, зумалсан ноос, сэв хялгас зэрэг түүхий эдийг ашиглан ноосыг дулааны аргаар боловсруулан төрөл бүрийн зориулалтын 1,620,000 м² ноосон дулаалга үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орж 2011-2019 онуудад эсгий, ноосон дулаалгын үйлдвэрлэлд 10,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 460 ажлын байр шинээр бий болгосон байна.

Ноосон дулаалгын үйлдвэрлэл импортыг орлох, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна. Япон зэрэг орнууд манай үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг сонирхож дээжийг нь өөрийн орондоо туршиж шинжилж байна.

Угаах үйлдвэрүүдийн ангилан ялгасан ноосыг ашиглан жилд 2000 тн хонины ноосон био бордоо үйлдвэрлэх үйлдвэр дэлхийд 2 дахь удаагаа, Монгол Улсад анх удаа ашиглалтанд орж 14 ажлын байрыг шинээр бий болгон экспортыг нэмэгдүүлэх шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжийг бүрдүүлж улмаар түүхий эдийн ашиглалтыг нэмэгдүүлэх боломжтой болсон.


1.6. Нэхэх, сүлжих үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

2011-2019 онуудад нийт 391,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай сүлжих үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орж, 1,000,000 ширхэг ноосон оймс үйлдвэрлэх хүчин чадал шинээр суурилагдаж олон зуун ажлын байрыг бий болгож, нэхэх үйлдвэрүүд шинэ техник технологи үйлдвэрлэлд нэвтрүүлснээр эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлж байна. Үүнд:

- Герман Улсад үйлдвэрлэсэн Dorner, CTM маркийн нэхэх машинуудын удирдлагын системийг шинэ дэвшилтэт технологиор сольж өөрчилснөөр программаас шалтгаалан гардаг гэмтэл сул зогсолт багасч хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн.

- Нанотехнологийн аргаар ус, хог болон шингэний гаралтай бохирдлыг шингээдэггүй өвөрмөц шинж чанартай даавуу (smart textile) гарган авах технологийг Монгол Улсад нутагшуулан Герман Улсын Котема фирмд зохион бүтээсэн 1 цагт 300 м даавуунд нано боловсруулалт хийх хүчин чадалтай шугамыг суурилуулан ашиглалтанд оруулсан ба уг машин дээр гэрийн бүрээсний зориулалттай даавуу боловсруулахаас гадна нанотехнологийн аргаар ус үл нэвчих хучлага, үул уурхайн ажлын хувцасны зориулалттай материалыг үйлдвэрлэх боломжтой.
- Жилд 500,000 уртааш метр ноосон даавуу үйлдвэрлэх, даавууны гүйцэтгэн боловсруулалт хийх иж бүрэн шугам шинээр суурилагдаж, монгол хонины ноосоор даавуу үйлдвэрлэх боломжтой болсон.
- Сүлжих үйлдвэрлэлд Герман Улсад үйлдвэрлэгдсэн STOLL фирмийн бүрэн автомат сүлжих машин суурилуулагдсанаар хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нэмэгдсэн.
- Сүлжих үйлдвэрлэлд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн бүрэн автомат сүлжих машинууд болон гүйцэтгэн боловсруулалтын тоног төхөөрөмжүүд суурилуулагдсанаар үйлдвэрлэлтийн хугацааг богиносгож, эцсийн бэлэн бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх боломжтой болгосон.

2. МОНГОЛЫН НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ



3. НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Төрөөс үүл үүрхайн бүс экспортыг дэмжих, ноосны үйлдвэрлэлийн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхээр

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого[1],
- “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”[2],
- “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”[3]-ыг түс түс батлан гаргаж салбарын хөгжлийн урт хугацааны зорилтуудыг тодорхойлсон.

Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол экспорт”[4] зэрэг хөтөлбөрүүдэд салбарын богино хугацааны зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна.

Зураг 3.1. Ноос боловсруулах үйлдвэрлэлийн салбарт төрөөс баримтлах бодлого



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он


2011 онд батлагдсан “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 30-р тогтоол нь ноос боловсруулах салбарт шинэ эрин үеийг авчирсан, түүнийг сэргээн хөгжүүлэх боломжийг нээж өгсөн түүхэн ач холбогдолтой бөгөөд уг тогтоолыг хэрэгжүүлснээр үндэсний үйлдвэрүүд түүхий эдийн хомсдлоос гарч, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж үйлдвэрлэгчид бүтээгдэхүүн үйлдвэрлэлт болон тухайн жилийн хэрэгцээт түүхий эдийн нөөц, түүхий эд бэлтгэлийн ажлаа төлөвлөх гүйцэтгэх улмаар техник технологийн шинэчлэлт хийх, шинээр үйлдвэр байгуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болсон.

[1] https://www.legalinfo.mn/law/details/15406?lawid=15406
[2] https://www.legalinfo.mn/law/details/13240?lawid=13240
[3] https://www.legalinfo.mn/law/details/4263?lawid=4263
[4] https://www.legalinfo.mn/law/details/13692?lawid=13692

4. НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН БҮТЭЦ

Ноос боловсруулах салбарт хивс үйлдвэрлэх 2 үйлдвэр, 4 нэхэх үйлдвэр, 9 ээрэх үйлдвэр, нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх 1 үйлдвэр, 28 угаах үйлдвэр, 23 хялгас ялгах үйлдвэр, 56 сүлжих үйлдвэр, эсгий эдлэл үйлдвэрлэх 16 үйлдвэр, ноосон бордоо үйлдвэрлэх 1 үйлдвэр, 120 эсгийлэх үйлдвэр, нийт 261 үйлдвэр, Эрдэм шинжилгээний хүрээлэн (Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн) - 1, Судалгаа хөгжлийн төв (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв) – 1 үйл ажиллагаа явуулж байна[5].

Зураг 4.1. Ноос боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бүтэц



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

5. НООСОН ТҮҮХИЙ ЭДИЙН НӨӨЦ

Монгол улс анх 1918 онд малаа тоолж байх үед нийт 9.6 сая толгой малтай байсан бол 2021 оны мал тооллогын дүнгээр малын тоо 67.34 сая толгойд хүрч, ямаа 26.46 сая толгой, хонь 31.09 сая толгой, үхэр 5.02 мянган толгой, адуу 4.32 мянган толгой, тэмээ 0.454 мянган толгой тоологдсон байна[6].


[5] ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2021 он
[6] www.1212.mn

Хүснэгт 5.1. Малын тоо, төрлөөр, 1930-2021 он, мян.толгой

Он	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1930	23,676.2	1,566.9	1,887.3	480.9	15,660.3	4,080.8
1940	26,204.8	2,358.1	2,722.8	643.4	15,384.2	5,096.3
1950	22,702.2	2,317.0	1,987.8	844.2	12,574.6	4,978.6
1960	23,000.5	2,502.7	1,905.5	859.1	12,101.9	5,631.3
1970	22,574.9	2,317.9	2,107.8	633.5	13,311.7	4,204.0
1980	23,771.4	1,985.4	2,397.1	591.5	14,230.7	4,566.7
1990	25,856.9	2,262.0	2,848.7	537.5	15,083.0	5,125.7
2000	30,227.5	2,660.8	3,097.6	322.9	13,876.3	10,269.8
2010	32,729.5	1,920.3	2,176.0	269.6	14,480.4	13,883.2
2011	36,335.8	2,112.9	2,339.7	280.1	15,668.5	15,934.6
2012	40,920.9	2,330.4	2,584.6	305.8	18,141.4	17,558.7
2013	45,144.3	2,619.4	2,909.5	321.5	20,066.4	19,227.6
2014	51,982.6	2,995.8	3,413.9	349.3	23,214.8	22,008.9
2015	55,979.8	3,295.3	3,780.4	368.0	24,943.1	23,592.9
2016	61,549.2	3,635.5	4,080.9	401.3	27,856.6	25,574.9
2017	66,219.0	3,939.8	4,388.5	434.1	30,109.9	27,346.7
2018	66,460.2	3,940.1	4,390.9	459.7	30,554.8	27,124.7
2019	70,969.3	4,214.8	4,753.2	472.4	32,267.3	29,261.7
2020	67,068.5	4,093.9	4,732.0	472.9	30,049.4	27,720.3
2021	67,343.8	4,324.4	5,022.2	454.0	31,087.0	26,456.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

График 5.1. Нийт малын тоонд малын төрөл тус бүрийн эзлэх хувийн жин, 1970-2021 он




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

Цаашид мал сүргийн бүтцэд анхаарч тэнцвэртэй тоог баримтлахгүй бол бэлчээрийн даац хэтрэх, бэлчээр сүйдэх зэрэг олон сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй байна. Тухайлбал, ус цаг уур, орчны шинжилгээний газраас жил бүр бэлчээр ашиглалтын нэгдсэн судалгааг хийдэг бөгөөд 2022-2023 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн 23.9% - 50 хүртэлх хувь (бэлчээрийн нөөцтэй), 15.6% - 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй), 34.4% - 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн), 7.7% - 301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн), 18.4% - 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн) байна. Өөрөөр хэлбэл өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 40 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, харин 60 гаруй хувьд

хэтэрсэн байна. Аймгийн дүнгээр авч үзвэл Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай аймгуудын ихэнх сум, багийн нутгаар даац хэтэрч гарсан байна[7].

Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжиж ноос түшаасан малчдад мөнгөн урамшуулал олгох тухай тогтоолууд хэрэгжиж эхэлснээр малчдын ноосноос олох орлого нэмэгдэж улмаар хонь тэмээн сүргээ өсгөх сонирхол нэмэгдсэн нь түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлэх эерэг үр дагаврыг бий болгосон.

График 5.2. Аймаг болон бүсүүдийн хонины тоо, мян.толгой



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

Хонин сүргийн тоогоор Архангай аймаг 2935.1 мянган толгой, Хөвсгөл аймаг 2883.2 мянган толгой, Хэнтий аймаг 2546.5 мянган толгой, Төв аймаг 2535.5 мянган толгой, Сүхбаатар аймаг 2179.0 мянган толгойгоор тэргүүлж байна (Хүснэгт 5.2-г харна уу).

Хүснэгт 5.2. Хонины тоо 2017-2021 он, мян.толгой

Баг, хороо	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	**30,109.9**	**30,554.8**	**32,267.3**	**30,049.4**	**31,087.0**
Баруун бүс	**6,903.2**	**6,606.9**	**6,729.7**	**6,431.8**	**6,885.7**
Завхан	1,837.7	1,827.5	1,950.9	1,799.8	1,919.5
Говь-Алтай	1,194.6	1,057.7	1,066.7	945.7	886.0
Баян-Өлгий	995.2	979.6	995.9	937.4	1,014.0
Ховд	1,323.6	1,174.2	1,111.3	1,126.3	1,267.8
Увс	1,552.1	1,568.0	1,604.8	1,622.7	1,798.4
Хангайн бүс	**11,329.0**	**11,459.3**	**12,243.5**	**10,553.5**	**10,749.5**
Орхон	47.7	47.5	50.6	51.2	59.6
Өвөрхангай	2,663.3	2,588.1	2,606.8	2,115.0	2,000.9
Булган	1,794.4	1,778.2	1,923.8	1,765.7	1,918.9
Баянхонгор	1,381.1	1,297.5	1,406.0	1,156.2	951.8
Архангай	2,845.1	2,981.8	3,321.3	2,842.6	2,935.1
Хөвсгөл	2,597.5	2,766.2	2,935.1	2,622.8	2,883.2
Төвийн бүс	**6,678.1**	**6,898.9**	**7,428.9**	**7,247.5**	**7,087.0**
Төв	2,461.1	2,449.3	2,619.8	2,540.3	2,535.5
Говьсүмбэр	205.2	208.1	219.5	218.4	219.4
Сэлэнгэ	699.3	705.9	744.7	783.4	849.7

[7] https://www.namem.gov.mn/view/3254

Дорноговь	861.5	926.2	1,021.6	1,069.7	1,158.5
Дархан-Уул	150.8	147.1	162.3	161.8	163.8
Өмнөговь	614.0	631.4	718.2	682.6	626.7
Дундговь	1,686.2	1,831.1	1,942.7	1,791.2	1,533.4
Зүүн бүс	**5,029.3**	**5,423.3**	**5,688.5**	**5,641.7**	**6,195.7**
Дорнод	1,001.6	1,147.7	1,262.4	1,303.1	1,470.2
Сүхбаатар	1,815.3	1,922.1	1,971.2	1,993.9	2,179.0
Хэнтий	2,212.5	2,353.5	2,454.9	2,344.7	2,546.5
Улаанбаатар	**170.2**	**166.3**	**176.7**	**174.9**	**169.0**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

Тэмээн сургийн тоогоор Өмнөговь аймаг 160.6 мянган толгой, Дорноговь аймаг 48.3 мянган толгой, Баянхонгор аймаг 45.5 мянган толгой, Говь-Алтай аймаг 43.7 мянган толгой, Дундговь аймаг 39.4 толгойгоор тэргүүлж байна (Хүснэгт 5.3-г харна уу).

Хүснэгт 5.3. Тэмээний тоо 2017-2021 он, мян.толгой

Баг, хороо	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	**434.1**	**459.7**	**472.4**	**472.9**	**454.0**
Баруун бүс	**103.9**	**107.6**	**109.8**	**108.6**	**111.9**
Завхан	7.5	7.8	8.0	8.1	8.3
Говь-Алтай	42.0	43.7	44.4	43.9	43.7
Баян-Өлгий	5.3	5.6	5.9	5.4	5.9
Ховд	25.7	25.4	25.8	25.7	27.6
Увс	23.5	25.1	25.6	25.5	26.4
Хангайн бүс	**88.1**	**93.8**	**96.1**	**87.1**	**70.1**
Орхон	0.0	0.1	0.1	0.1	0.1
Өвөрхангай	28.8	31.5	32.7	26.6	19.0
Булган	1.4	1.4	1.5	1.4	1.5
Баянхонгор	54.3	57.4	58.1	55.5	45.5
Архангай	1.4	1.3	1.4	1.3	1.7
Хөвсгөл	2.2	2.3	2.4	2.3	2.4
Төвийн бүс	**223.8**	**239.5**	**247.7**	**259.1**	**253.6**
Төв	3.5	3.5	3.6	3.6	3.7
Говьсүмбэр	0.9	1.1	1.0	1.1	1.1
Сэлэнгэ	0.5	0.5	0.5	0.4	0.5
Дорноговь	40.7	42.8	43.5	45.4	48.3
Дархан-Уул	0.0	0.1	0.1	0.1	0.1
Өмнөговь	141.2	152.3	157.9	166.8	160.6
Дундговь	36.8	39.3	41.3	41.7	39.4
Зүүн бүс	**18.1**	**18.6**	**18.5**	**17.9**	**18.4**
Дорнод	5.6	6.1	6.3	6.2	6.5
Сүхбаатар	8.3	8.2	7.9	7.6	7.7
Хэнтий	4.2	4.3	4.3	4.0	4.1
Улаанбаатар	**0.3**	**0.2**	**0.3**	**0.2**	**0.1**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

Ноосны урамшуулал хэрэгжиж эхэлснээс хойш хонь болон тэмээн сургийн тоо жилээс жилд тасралтгүй өсч 2010 онд тоологдсон хонь тэмээний тоотой харьцуулахад 2021 онд хонь 207.52%-иар, тэмээ 159.45%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 5.4. Хонь, тэмээний тоо 2016-2021 он, мян.толгой

Бүс, аймаг	Хонь	Тэмээ
2010	14,480.40	269.60
2011	15,668.50	280.10
2012	18,141.36	305.84
2013	20,066.43	321.48
2014	23,214.78	349.30
2015	24,943.13	367.99
2016	27,856.60	401.35
2017	30,109.89	434.10
2018	30,554.80	459.70
2019	32,267.27	472.38
2020	30,049.43	472.93
2021	31,086.96	454.04

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

6. НООСОН ТҮҮХИЙ ЭДИЙН БЭЛТГЭЛ

Ноосон түүхий эд нь жил бүр нөхөн сэргээгддэг, үндэсний шавхагдашгүй үнэт баялаг бөгөөд ноос нь хиймэл, нийлэг мяндсыг бодвол дулааныг хадгалах, дамжуулах, сунах, агших, уян хатан чанар, бөх батаараа илүүгээс гадна хүний бие махбод эрүүл ахуйд онц тохиромжтой учир ноосон нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, даавуу, цэмбэ, ноосон хөнжил, хивс, эсгий, эсгий гутал үйлдвэрлэдэг.

Төрөл бүрийн мал, ан амьтны үс ноосыг бэлтгэн ашиглаж байгаагаас хонины ноос нь хэмжээ, чанарын хувьд илүү ашигтай, өргөн хэрэгцээний түүхий эдэд тооцогддог. Хонины ноос нь арьснаас гаралтай эвэрлэг эд бөгөөд үсний ширхэгүүд нь арьсан дотор үүсч ургаж уртассаар хонины биеийг үсэн бүрхүүлээр хучна.

Хонины үргэлж ноосонд байх ноолуур, сор, завсрын үс болон хялгасны хэмжээг харгалзан бүдүүн[8], бүдүүвтэр[9] гэж ангилдаг. Бүдүүн ноос нь ноолуур, завсрын үс, сор болон хялгаснаас бүрдсэн жигд бус тогтоцтой байдаг. Бүдүүвтэр ноос нь хялгаснаас бусад ноолуур, завсрын үс, сор үс гэсэн ширхэгтээс бүрдсэн байдаг.

Нарийн ноост[10] хонины ноос нь дан ноолууraас, нарийвтар ноост[11] хонины ноос нь ноолуур, завсрын үснээс бүрдсэн байна. Ийм ноос нь жигд долгиотсон атриатай, гялалзсан өнгөлөг, уян хатан, бат бөх, хэвийн зунгагтай, багц үсний үзүүр хэсэг нь хуурайшсан байдаг.

Хонины ноосыг ургалт, хяргалтын хугацааг харгалзан уртын, ахарын, хурганы гэж ангилдаг.

Бүтэн жилийн турш ургасан ноосыг *уртын ноос* гэнэ.

Зун хяргаснаас хойш ургаж, намар хяргаж авсан ноосыг *ахар ноос* гэнэ.

---

[8] **Бүдүүн ноос (Coarse wool)** - Ноолуур, завсрын үс, сор, хялгаснаас тогтсон, туг хэлбэртэй, бат бэх, хэвийн зунгагтай, төрөл бүрийн үсний харьцаа харилцан адилгүй ноос, MNS 33:2007

[9] **Бүдүүвтэр ноос (Semi-coarse wool)** – Ноолуур, завсрын үс, сор холилдсон, жигд биш, урт, хэвийн зунгагтай, уян хатан, бат бэх, үргэлж ноосны үндсэн хэсэгт хялгасгүй, хонго, хээлүүр, хүзүүний ноосонд хялгас бага зэрэг тохиолдох ноос, MNS 33:2007

[10] **Нарийн ноос (Fine wool)** – Багц үс нь дан ноолууraас тогтсон, нарийн зөөлөн, угаасаа үзүүр хүртэл жигд атираатай, бат бэх, хэвийн зунгагтай ноос, MNS 33:2007

[11] **Нарийвтар ноос (Semi-fine wool)** – Багц үс нь ноолуур, завсрын үснээс тогтсон, жигд долгиолсон атираатай, нарийн, уян хатан, бат бэх, багц үсний үзүүр нь хуурайвтар, хэвийн зунгагтай ноос, MNS 33:2007

Тухайн жилийн хавар гарсан 5-6 сартай хурганы ноосыг зун хяргаж авсаныг *хурганы ноос* гэнэ.

Нарийн, нарийвтар ноост хонийг ахарлахгүй, хурганы ноосыг авч болохгүй. Жинхэнэ ноос нь өнгө үзэмж, дулаан хадгалах, бөх бат, суналт, уян хатан зэрэг техникийн хувьд бусад ширхэгтээс ялгагдах онцлогтой байдаг. Мөн ноос ба ноосон эдлэл чийг татах чанараар муу, амархан хатахгүй, будаг амархан авдаг зэрэг үнэт чанарыг агуулна. Ялангуяа ноос бусад төрлийн ширхэгтэд байхгүй даахирах чанарыг агуулсан байдгаараа онцлог юм. Хонины ноосны бүрэлдэхүүн дэхь үсний ширхгүүдийн хайрслаг давхарга нь арзгар ширүүн учраас эсгий ба эсгий эдлэл хийхэд тохиромжтой.

Монголчууд ноосыг савж, зулж гар аргаар эсгий, эсгий бүтээгдэхүүн эдлэл, ноосыг ээрч хивс нэхэж ноосон хувцас эдлэл хийж хэрэглэж ирсэн уламжлалтай[12].

Манай орон нь ноосон түүхий эдээр баялаг бөгөөд бэлчээрийн хонины аж ахуйнуудад голлон үржүүлдэг бүдүүн ноост хонь нь хивс эсгий, эсгий гутлын болон нэхээсгүй нэхмэлийн үйлдвэрлэлд нэн тохиромжтой хамгийн хямд, хамгийн их нөөцтэй түүхий эд юм[13].

Хүснэгт 6.1. 2021 оны ноос бэлтгэлийн тооцоо

Аймаг, хот	2021 оны хонины тоо, толгой	Ноосны гарц, кг	Бэлтгэх ноосны хэмжээ, тн	Бэлтгэх ноосны хэмжээ, тн
Улсын дүн	**31,086,963**	**1.266**	**36,719,651**	**36,719.65**
Баруун бүс	**6,885,682**	**1.451**	**9,917,419**	**9,917.42**
Завхан	1,919,536	1.600	3,071,258	3,071.26
Говь-Алтай	885,992	1.640	1,453,027	1,453.03
Баян-Өлгий	1,013,977	1.315	1,333,380	1,333.38
Ховд	1,267,809	1.500	1,901,714	1,901.71
Увс	1,798,368	1.200	2,158,042	2,158.04
Хангайн бүс	**10,749,525**	**1.221**	**10,768,228**	**10,768.23**
Орхон	59,648	1.300	77,542	77.54
Өвөрхангай	200,089	1.200	240,107	240.11
Булган	1,918,925	1.200	2,302,710	2,302.71
Баянхонгор	951,776	1.225	1,165,926	1,165.93
Архангай	2,935,059	1.200	3,522,071	3,522.07
Хөвсгөл	2,883,227	1.200	3,459,872	3,459.87
Төвийн бүс	**7,087,033**	**1.290**	**8,435,719**	**8,435.72**
Төв	2,535,482	1.100	2,789,030	2,789.03
Говьсүмбэр	21,942	1.330	29,183	29.18
Сэлэнгэ	849,736	1.600	1,359,578	1,359.58
Дорноговь	1,158,465	1.200	1,390,158	1,390.16
Дархан-Уул	163,834	1.300	212,984	212.98
Өмнөговь	626,707	1.300	814,719	814.72
Дундговь	1,533,389	1.200	1,840,067	1,840.07
Зүүн бүс	**6,195,717**	**1.167**	**7,395,478**	**7,395.48**
Дорнод	1,470,176	1.000	1,470,176	1,470.18
Сүхбаатар	2,179,012	1.200	2,614,814	2,614.81
Хэнтий	2,546,529	1.300	3,310,488	3,310.49
Улаанбаатар	**169,006**	**1.200**	**202,807**	**202.81**

Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2021 он

[12] Ноос, ноолуур бэлтгэл, Улаанбаатар 2012 он

[13] Ю.Дашбал “Монгол дахь ноосон нэхмэлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх асуудалд”, Улаанбаатар хот, 2012 он

2021 онд 36.7 мянган тонн ноос бэлтгэх тооцоо гарсан бол олон улсын IWTO байгууллалын статистик мэдээгээр 36.8* мянган тонн ноос манай улс бэлтгэсэн байна[14].

Хүснэгт 6.2. Хонины ноос бэлтгэлийн хэмжээ 2011-2021 он

Он	МУ-ын ноосны нөөц /тн/	Үйлдвэрүүдийн бэлтгэсэн хэмжээ /мян.тн/	Бэлтгэсэн хэмжээ /нөөцөд эзлэх %/
2011	16,166.20	4.7	29.0%
2012	17,486.90	14.2	81.1%
2013	20,229.20	18.3	90.6%
2014	22,318.70	18.9	84.8%
2015	25,820.80	18.2	70.5%
2016	27,399.80	17.6	64.2%
2017	30,626.50	20.5	67.0%
2018	33,013.36	20.2	61.2%
2019	33,692.00	16.6	49.3%
2020	35,565.90	13.2	37.1%
2021	36,800.00*	19.9	54.08%

Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

** IWTO, Market Information Edition 17, Statistics for the Global Wool Production and Textile Industry, 39p*

График 6.1. Хонины ноос ашиглалтын харьцаа, мян.тн



Эх сурвалж: Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn, ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

Хүснэгт 6.3. Тэмээний ноос бэлтгэлийн хэмжээ 2011-2021 он

Он	МУ-ын тэмээний ноосны нөөц /тн/	Үйлдвэрүүдийн бэлтгэсэн хэмжээ /мян.тн/	Бэлтгэсэн хэмжээ /нөөцөд эзлэх хувь, %/
2011	1,100	0.2	18,2%
2012	1,100	1.0	90,9%
2013	1,200	1.2	100%
2014	1,300	1.1	84,6%
2015	1,400	0.9	64,3%
2016	1,734.7	1.1	73,3%
2017	1,894.1	1.2	75%
2018	2,047.1	0.8	47,1%
2019	2,175.1	0.4	22,2%
2020	2,237.8		


[14] ** IWTO, Market Information Edition 17, Statistics for the Global Wool Production and Textile Industry, 39p*

2021	1,900.0*	0.849	44.7%

Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

**"Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 2022*

График 6.2. Тэмээний ноос ашиглалтын харьцаа, мян.тн



Эх сурвалж: Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2021, www.1212.mn,


ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

7. НООСОН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Дэлхийн зах зээл дээр ноосны үнэ 2020 оны 3-р сараас 9-р сар хүртэл мэдэгдэхүйц буурсан нь COVID-19 тахлын нөлөөллийн хариу юм[15].

Дэлхийн ноосны үнэ 2020 оны эхний хагаст огцом унасны дараа 2020 оны сүүлийн хагаст ерөнхийдөө сайжирч эхэлсэн. Энэ сайжруулалт 2021 он хүртэл үргэлжилсэн. Дараа нь үнэ 2021 оны ихэнх хугацаанд ижил түвшинд тогтворгүй байсан. Үүний эсрэгээр, өрсөлдөгч утаснуудын үнэ ноосны үнээс илүү тогтвортой, тогтвортой байдлаар сайжирсан.

График 7.1. Дэлхийн ноосны үнэ 2021 оны төгсгөлтэй харьцуулахад 2020 оны төгсгөл (% өөрчлөлт)




Эх сурвалж: IWTO, Market Information Edition 17, Statistics for the Global Wool Production and Textile Industry, 56p

[15] *IWTO Market information, Edition 16*

Дэлхийн зах зээлд 19 микрон ба түүнээс дээш хэмжээтэй ноосны үнэ харьцангуй сул сэргэж байгаагаас ялгаатай нь гол өрсөлдөгч утаснуудын үнэ (хөвөн ба хиймэл утас) сүүлийн 12-18 сарын хугацаанд тахлын улмаас үүссэн доод түвшнээс маш хүчтэй сайжирсан байна. Тахал өвчний эдгээр өрсөлдөж буй утаснуудын үнэд үзүүлэх нөлөө нь ноосны үнэд үзүүлэх нөлөөлөөс илүү сул байсан тул өрсөлдөх утаснуудын үнийн одоогийн түвшин нэлээд өндөр байна.

График 7.2-т Австрали, Өмнөд Африк, Шинэ Зеланд, Их Британи дахь янз бүрийн төрлийн ноосны үнийн чиг хандлагыг, түүнчлэн өөр хоорондоо өрсөлдөж буй утаснуудын үнийн хандлагыг харуулав.

График 7.2. Нэхмэлийн ширхэгтийн үнийн чиг хандлага, долларын индекс: 2020 оны 1-р сар=100



Эх сурвалж: IWTO, Market Information Edition 17, Statistics for the Global Wool Production and Textile Industry, 16p

2020/21 оны улиралд дэлхийн хөвөнгийн үйлдвэрлэл буурсны дараа 2021 онд хөвөнгийн эрэлт нэмэгдсэн тул 2021 оны арванхоёрдугаар сард хөвөнгийн үнэ 2021 оны нэгдүгээр сарынхаас 39 хувиар өндөр байна.

Дэлхийн ноосны үйлдвэрлэл 2021 онд бага зэрэг сэргэсэн ч цэвэр жингийн хувьд ердөө 0.3%-иар өссөн байна. Үүний зэрэгцээ дэлхийн хөвөнгийн үйлдвэрлэл 7.7 хувиар буурчээ. Нийтдээ байгалийн 2 ширхэгтийн үйлдвэрлэл 2021 онд 6.9%-иар буурсан байна.

Үүний эсрэгээр, дэлхийн хиймэл утас (газрын тосны болон целлюлозын аль аль нь) үйлдвэрлэл 2020 онд 0.9%-иар бага зэрэг буурсаны дараа 13.7%-иар нэмэгдэж, шинэ дээд амжилт тогтоосон байна. Байгалийн утаснууд эдгээр хиймэл утаснаас ихээхэн дарамттай тулгарч байна.

Дэлхийн ноосны үйлдвэрлэл 2022 онд дахин өсөх төлөвтэй байгаа бөгөөд энэ нь улирлын чанартай маш сайн нөхцөл байдлын хариуд Австралийн үйлдвэрлэлийн урьдчилсан таамаглалд голчлон 1.6%-иар мэдэгдэхүйц 9.9%-иар нэмэгдэх төлөвтэй байна. Мөн Түрк, Их Британид ноосны үйлдвэрлэл нэмэгдэх төлөвтэй байна. Үүнийг Шинэ Зеланд, Хятад, Өмнөд Африк, Аргентин, Уругвай, Монгол зэрэг бусад орны үйлдвэрлэлийн бууралтаар нөхөх болно.

Манай улсын БНХАУ руу угаасан, самнасан ноосыг экспортлодог тул тус орны ноосны үнийг мөн судаллаа.


Хүснэгт 7.1. БНХАУ-ын ноосны үнэ, (RMB/кг)

Улирал	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	Улирлын дундаж	доллар/кг улирлын дундаж
2000-01	38.30	38.20	38.30	38.10	37.80	37.40	37.10	37.20	36.80	37.20	37.10	37.10	37.55	4.54
2001-02	37.30	37.30	37.30	36.90	36.20	35.60	35.50	36.80	38.80	38.60	39.40	41.20	37.58	4.54
2002-03	43.00	43.50	44.20	50.30	50.40	49.50	50.00	52.80	53.60	52.80	50.60	49.40	49.18	5.94
2003-04	51.40	51.60	51.40	51.50	50.90	49.80	49.80	50.10	49.40	48.80	48.00	48.40	50.09	6.05
2004-05	49.50	49.20	48.20	47.30	46.90	46.60	46.00	45.60	46.10	46.00	46.00	45.60	46.92	5.68
2005-06	45.90	44.70	44.50	44.80	44.70	44.00	44.20	44.60	44.50	44.10	44.10	44.30	44.53	5.51
2006-07	43.70	44.60	44.50	44.20	45.30	46.90	49.00	52.80	52.90	54.30	58.80	62.60	49.97	6.38
2007-08	64.20	61.90	67.80	60.80	63.50	63.50	63.10	63.00	64.40	63.40	60.50	60.00	63.01	9.07
2008-09	59.70	59.20	55.80	54.20	48.80	49.60	49.70	44.10	41.00	41.20	42.90	44.60	49.23	7.20
2009-10	43.60	44.00	46.90	49.80	51.70	53.90	55.80	58.70	58.60	58.20	57.80	56.80	52.98	7.76
2010-11	55.20	55.00	55.30	56.90	59.80	61.00	62.60	70.70	73.60	78.40	87.60	93.50	67.47	10.18
2011-12	94.30	84.90	79.20	75.00	76.90	74.50	76.70	77.50	79.90	79.00	76.60	74.50	79.08	12.47
2012-13	73.70	73.40	70.80	69.60	68.90	68.90	68.70	69.20	69.50	68.70	68.10	67.20	69.73	11.16
2013-14	64.80	63.00	64.30	65.00	65.00	65.10	66.00	65.10	63.60	62.00	62.20	62.40	64.04	10.42
2014-15	62.20	62.30	62.40	62.00	62.00	62.10	61.80	61.33	60.60	58.70	60.00	71.60	62.30	9.72
2015-16	71.30	69.90	69.00	68.40	66.70	66.70	66.00	65.00	64.70	62.60	62.70	64.30	66.40	9.91
2016-17	73.20	79.80	82.40	83.27	83.80	84.07	83.60	84.60	84.20	83.60	84.00	87.50	82.84	12.71
2017-18	86.50	87.00	87.00	87.00	88.20	90.00	90.00	91.00	92.20	94.50	96.50	105.00	91.24	14.07
2018-19	107.50	109.50	112.50	106.50	106.50	112.50	112.50	112.75	113.50	105.25	94.50	91.50	107.80	15.60
2019-20	86.10	82.60	86.50	81.00	80.50	77.75	77.75	77.75	60.00	60.00	60.00	60.00	74.16	10.73
2020-21	60.00	59.50	61.88	62.25	63.00		55.50	60.75	67.13	67.50	67.50	67.50	62.33	9.43
2021-22*	67.50	67.50	67.50	67.50	67.50								67.50*	10.50*

*Эх сурвалж: Nanjing Wool Market, *2021/22 is for the season to November 2021*

Эх сурвалж: IWTO Market information, Edition 17

График 7.3. БНХАУ-ын ноосны дээд үнэ, улирлын дунджаар




Эх сурвалж: IWTO, Market Information Edition 17, Statistics for the Global Wool Production and Textile Industry, 56p

Бүх утаснуудын дэлхийн үйлдвэрлэл 2021 онд 8.1%-иар нэмэгдэж, нийт 112,828 мкг-д хүрч шинэ рекорд тогтоосон байна. Энэ бүх өсөлт нь 13.7%-иар өссөн хиймэл ширхэгтийн үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой. Үүнээс тосонд суурилсан синтетик бүтээгдэхүүний үйлдвэрлэл 14.1%-иар, целлюлозын үйлдвэрлэл 9%-иар өссөн байна. Дэлхийн ширхэгтийн хэрэглээ 14.4%-иар өсч, нэхмэлийн үндсэн утас бүрийн хэрэглээ нэмэгдэж, тэр ч байтугай зарим илүүдэл нөөцийг борлуулснаар хөвөнгийн хэрэглээ нэмэгджээ.

График 7.4-т 2000 оноос хойш хувцасны ноос, интерьерийн ноосон нэхмэл, мерино ноосны дэлхийн үйлдвэрлэлийн чиг хандлагыг харуулав. Мерино ноосны үйлдвэрлэл нь хувцасны ноосны үйлдвэрлэлийн дэд хэсэг юм.

График 7.4. Дэлхийн ноосны үйлдвэрлэл, төрлөөр



Эх сурвалж: IWTO, Market Information Edition 17, Statistics for the Global Wool Production and Textile Industry, 18p

Ноосон түүхий эдийн үнэ олон зүйлээс шалтгаалж байнга хэлбэлзэж байдаг. Хамгийн гол нь ноосон түүхий эд улирлын чанартай бэлтгэгддэг тул түүхий эд худалдан авахад богино хугацаанд их хэмжээний эргэлтийн хөрөнгө шаардагддаг.

2021 онд Ковид-19 цар тахлын улмаас дэлхий нийтэд эдийн засгийн хямралтай холбоотой ноосон түүхий эдийн үнэ унасан тул манай орны ноосон түүхий эдийн үнэ ч унасан.

Хүснэгт 7.2. Хонь, тэмээний ноосны үнэ, төг

Ноосны төрөл	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Хонины ноос	500-1,000	700 – 1,800	2,000 – 3,200	2,500 – 4,600	1,000-1,500	700-800	
Тэмээний ноос	3,800-4,200	4,700 – 4,800	5,000 – 5,200	14,500 – 18,000		3,500-4,500	
Сарлагийн хөөвөр	9,000-10,000	10,000 – 12,000	12,000 – 14,000	23,000 – 27,000			

Эх сурвалж: ХХААХҮЯ, ХӨҮБХЗГ, 21 аймгийн ХХААГ

Жич: 21 аймгаас авсан түүхий эдийн үнэ ханшийн мэдээг нэгтгэн дундажийг гаргав.

8. НООСНЫ УРАМШУУЛЛЫН ҮР ДҮН

Үндэсний үйлдвэрт ноос бэлтгэн нийлүүлсэн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгож, салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлттэй зээлийг олгон үнэгүйдэн хаягдаж байсан ноосон түүхий эдийг үндэсний боловсруулах үйлдвэрт тогтвортой нийлүүлэх бодлогын арга хэмжээг 2011-2021 онуудад авч хэрэгжүүлснээр үйлдвэрүүд тогтвортой түүхий эдээр хангагдаж, техник технологио шинэчилж, бүтээгдэхүүний экспортоо нэмэгдүүлсэн юм.

”Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 6-р сарын 03-ны өдрийн 30-р тогтоолын дагуу Хялгас ялгах, ээрэх, нэхэх эсвэл сүлжих иж бүрэн дамжлагуудтай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр, эсгийлэх техник, технологи бүхий дамжлагуудтай эсгий, эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр, ноосоор бордоо үйлдвэрлэх, дулаалгын материал зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боловсруулах үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчинд өмнөх жилийн эцсийн мал тооллогын А данс дахь малын тоо, үүлдэрлэг байдал, ашиг шим, ноосны чанараас хамааран тэмээний ноосонд кг тутамд 2,000 төгрөг, хонины ноосонд кг тутамд 1,500 төгрөг олгож байна.


Хонь тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд төрөөс мөнгөн урамшуулал олгож эхэлсэн. Уг тогтоолын дагуу 2011-2021 онуудад үндэсний үйлдвэрт ноос тушаасан малчдад 225.4 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Хүснэгт 8.1. Ноосны урамшууллын хэрэгжилт, 2011-2021

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Бэлтгэсэн ноос, мян.тн	4.7	14.2	18.3	18.9	18.2	17.6	20.5	20.2	16.6	13.2	19.9
Урамшуулалд хамрагдсан малчны тоо	32,977	103,162	116,668	84,600	80,619	79,500	92,885	86,900	70,752	46,828	91,977
Олгосон урамшууллын мөнгөн дүн, сая.төг	9,852.2	29,414.3	18,291.2	18,264.1	18,267.2	19,376.4	22,631.2	22,519.2	18,599.9	19,419.5	32,367

Эх сурвалж: ХХААХҮЯ, СХОГ, 2022 он

График 8.1. Монгол улсын нийт бэлтгэсэн ноос ба урамшууллаар бэлтгэсэн ноосны харьцуулалт, мян.тн




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

** IWTO, Market Information Edition 17, Statistics for the Global Wool Production and Textile Industry, 39p*

График 8.2. Монгол улсын нийт малчны тоо ба урамшуулалд хамрагдсан малчны тоо, н.тн




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn

ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

2011-2021 онуудад үндэсний үйлдвэрт ноос тушаасан 886,868 малчдад 225.4 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг олгож, үндэсний үйлдвэрүүд малчин, мал бүхий этгээдээс 182.3 мян.тн ноос бэлтгэсэн байна.

График 8.3. Урамшууллаар бэлтгэсэн ноосны хэмжээ, аймгаар, 2016-2020 он, мян.тн



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

9. НООСНЫ САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

”Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 30-р тогтоолийн хүрээнд Мал аж ахуйн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосон. Уг тогтоолын дагуу 2011-2013 онуудад ноос боловсруулах салбарын 24 үйлдвэрт 31.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож үйлдвэрүүд тоног төхөөрөмжийн шинэчлэлд 12.9 тэрбум төгрөг, үйлдвэрийн өргөтгөл засварт 5.1 тэрбум төгрөг, эргэлтийн хөрөнгө худалдан авахад 13.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

”Үйлдвэрлэлийг дэмжих тухай” Засгийн Газрын 2013 оны 4-р сарын 13-ны өдрийн 141-р тогтоолоор ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх санхүүжилтийн эх үүсвэрийн гуравны нэгтэй тэнцэх 45 сая хүртэлх ам.долларын (70,7 тэрбум төгрөг) зээл олгохоор шийдвэрлэсэн. Уг тогтоолын дагуу 2015 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар нийт 17 үйлдвэрийн төсөлд 48.2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

”Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 30-р тогтоол болон ”Үйлдвэрлэлийг дэмжих тухай” Засгийн Газрын 2013 оны 141-р тогтоол хэрэгжилтийн үр дүнд ноос боловсруулах салбарт техник технологийн

шинэчлэлт хийгдэж ололт амжилт бий болсоор байгаа бөгөөд 2012-2019 онуудад ноос боловсруулах салбарт шинээр 1,882 ажлын байр нэмэгдэж нийт 278.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт оруулсан байна.

2021 онд ноос боловсруулах салбарын үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн хөрөнгөөр шинэ техник, тоног төхөөрөмж суурилуулах, үйлдвэрлэлийн дэд бүтцийг шинэчлэх, ажлын байрыг өргөтгөхөд 3.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Хүснэгт 9.1. Ноосны үйлдвэрлэлийн салбарын 2021 оны хөрөнгө оруулалт

Д/д	Үйлдвэрийн нэр	Нэвтрүүлсэн дэвшилтэт техник технологи	Хөрөнгө оруулалтын мөнгөн дүн, сая төгрөг
1	Бохирго даваа ХХК	Ноос сэмлэх машин нэмж суурилуулсан.	4.0
2	Вүүл ворлд и кей эс ХХК	Хялгас ялгах шугам шинээр нэмж суурилуулан хүч чадлаа нэмэгдүүлсэн. Лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж худалдаж авсан.	526.9
3	Дөрвөн булаг Увс ХХК	Ноос угаах үйлдвэр ашиглалтад оруулсан.	500.0
4	Дөрвөн гэгээн эрдэнэ ХХК	Бутлах төхөөрөмж шинээр суурилуулсан.	0.800
5	Жавхлант гүрэм Хоршоо	Эсгий хагас угаагч машин суурилуулсан.	4.5
6	Жин корона ХХК	Өөрөө өргөгч машин шинээр суурилуулсан.	50.0
7	Жи эс эф ХХК	Бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулсан.	360.0
8	Кенже дара ХХК	Ноос самнах машин шинээр суурилуулсан.	
9	Лидер кашмир ХХК	Улаанбаатар хот дахь угаах үйлдвэртээ уурын шугам татаж ашиглалтад оруулсан бөгөөд мэргэжлийн байгууллагын шаардлагад нийцсэн саарал ус гаргах цэвэршүүлэх байгууламжуудыг бүх шатны үйлдвэрүүдэд нэвтрүүлсэн. Жилд 25,000 хос оймс үйлдвэрлэх хүчин чадалтай машинуудыг суурилуулж, сүлжих үйлдвэртээ нэмж оймсны үйлдвэр байгуулсан.	327.8
10	Мөнгөн зээг Хоршоо	6*9 м, 9*10 м хэмжээтэй ажлын байр шинээр ашиглалтанд оруулсан. Богийн арьс боловсруулах үйлдвэр шинээр байгуулсан.	17.0
11	Наран золбоот кашмир ХХК	Бохир ус цэвэршүүлэх байгууламж шинээр суурилуулан, үйлдвэрлэлд ашигласан усныхаа 70-80%-ийг саарал ус болгон буцаан ашиглах технологийг нэвтрүүлж байна.	460.0
12	Нүүрэнтэйн эсгий ХХК	Байгальд ээлтэй Эколос цэвэрлэх байгууламж суурилуулсан.	53.0
13	Тэнүүн говийн баялаг ХХК	Самнах машин шинээр суурилуулсан.	25.0
14	Улаанбаатар хивс ХК	Хялгас ялгах цехийг ажиллуулахаар цехийн бичил орчинг сайжруулах зорилгоор чийгшүүлэх аппарат 2 ширхэгийг авч тавьсан мөн шаардлагатай бусад төхөөрөмжүүдийг суурилуулсан.	216.7
15	Уран нинж ХХК	Ноос бутлах болон хөнжлийн машин нэмж суурилуулсан.	150.0
16	Халх гэр хийц ХХК	Ажлын байр шинээр ашиглалтанд оруулж ажилчдаа тав тухтай ажиллах боломжийг бүрдүүлсэн мөн 1 ширхэг самнах машин шинээр суурилуулсан.	300.0
17	Ханбогд кашмир ХХК	20 квт цахилгаан эрчим хүч гаргах хүчин чадалтай нарны зайн цахилгаан үүсгэвэр суурилуулсан.	50.9
		Цэвэрлэх байгууламж суурилуулж үйлдвэрээс гарсан бохир усыг саарал ус болгон ашиглаж байна. Үйлдвэрээс гарсан лагийг хатааж пресслэн хогийн цэгт хаясан.	246.0

18	Хурнуурын булаг Хоршоо	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар хийсэн.	0.250
19	Үлэмж кашмир ХХК	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн.	10.0
	Нийт дүн		**3,302.85**

Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

"Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 2022

10. НООСОН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН СУУРИЛАГДСАН ХҮЧ ЧАДАЛ БА АШИГЛАЛТ

Ноос боловсруулах салбарт 2020 оны байдлаар 1.6 сая.м² хивс, 71,400 тн ноос угаах, 3,289 тн самнасан ноос үйлдвэрлэх, 3,293 тн ээрмэл, 1,243,000 ширхэг сүлжмэл, 2,500,000 ширхэг ноосон оймс, 817,0 мян.м² нэхмэл, 500,0 мян.м² ноосон даавуу, 1,260.0 мян.м² нэхээсгүй эдлэл, 4,106.7 мян.м² эсгий, 1,620 мян.м² дулаалгын материал, 2000 тн ноосон бордоо үйлдвэрлэх хүч чадал суурилагдсан байна.

Хүснэгт 10.1. Ноос боловсруулах үйлдвэрлэлийн салбарын суурилагдсан хүч чадал

№	Дамжлага	Хэмжих нэгж	Суурилагдсан хүчин чадал: 2011 он	Нэмж суурилагдсан 2012-2020	Суурилагдсан хүчин чадал: 2020 он	Өсөлт, %
1	Угаах	мян.тн	25.0	46.4	71.4	185,6
2	Хялгас ялгах	тн	552.0	2,737.0	3,289.0	495,8
3	Ээрэх	тн	2,763	530	3,293	19,2
4	Сүлжих	мян.ш	852.0	391.0	1,243.0	45,9
5	Сүлжих /оймс	мян.ш	1,500.0	1,000.0	2,500.0	66,7
6	Нэхэх	мян.м²	557.0	260.0	817.0	46,7
7	Эсгийлэх	мян.м²	3,147.5	959.2	4,106.7	30,5
8	Ноосон дулаалга	мян.м²	-	1,620.0	1,620.0	100
9	Ноосон даавуу	мян.м²	-	500.0	500.0	100
10	Ноосон бордоо	тн	-	2,000	2,000	100

Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

График 10.1. Угаах үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал





График 10.2. Хялгас ялгах үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

График 10.3. Ээрэх үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал





График 10.4. Нэхэх үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

График 10.5. Оймс сүлжих үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал





График 10.6. Сүлжих үйлдвэрлэлийн нэмж суурилагдсан хүч чадал



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

Хүч чадал ашиглалтын түвшин 2020 оны байдлаар. Ноосны урамшуулал хэрэгжиж эхэлснээс хойш түс салбарт хийгдэж буй техник технологийн шинэчлэлт, бий болж байгаа ололт амжилтуудын үр дүнд “Монгол Улсын тогтвортой байдлын үзэл баримтлал 2030”-д заасан ноос ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшинг 2021 онд 60%-д, 2030 онд 80%-д хүргэх зорилтыг хэрэгжүүлэх үндэс суурь тавигдсан.

Гэвч улс орны нийгэм эдийн засгийн байдал, хүн амын орлогын түвшин, гадаад дотоод зах зээл дэх борлуулалт харьцангуй бага байгаа зэрэг нөхцөлүүдийн улмаас үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал үйлдвэрлэлийн төрлөөсөө хамааран 5-61%-ийн ашиглалттай байна.

Энэхүү хүчин чадлын ашиглалтыг авч үзвэл угаах 41 хувь, самнах 51 хувь, ээрэх 46 хувь, сүлжих, нэхэх 48 хувь, хивс 45 хувь, нэхээсгүй эдлэл 57 хувь, эсгий 61 хувь, ноосон дулаалгын материал 5 хувийн ашиглалттай байна. Дотоодод үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүнтэй

ижил төстэй бараанууд импортоор их хэмжээгээр орж ирэн төрийн байгууллагуудын болон иргэдийн хэрэгцээнд зориулагдан борлуулагдаж байгаа ба хямд үнэтэй импортын бараатай дотоодын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадвар сул байна.

График 10.7. Салбарын суурилагдсан хүч чадал ба хүч чадал ашиглалтын харьцаа

Угаах, самнах, ээрэх, нэхэх, сүлжих





График 10.8. Салбарын суурилагдсан хүч чадал ба хүч чадал ашиглалтын харьцаа

Хивс, нэхээсгүй эдлэл, дулаалга



Эх сурвалж: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2022 он

11. НООСОН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол Улсаас жилд бэлтгэгдэж байгаа ноосон түүхий эдийн нөөц нь үндэсний үйлдвэрүүдийн жилийн нийт хэрэгцээний 65-70%-тай тэнцэх хэмжээтэй байдаг. Түүхий эдийн хүрэлцээ хангамж, бүтээгдэхүүн борлуулах дотоод гадаад зах зээлийн багтаамж, улс орны нийгэм эдийн засгийн байдал, хүн амын орлогын түвшин зэрэг нөхцөлүүд нь үйлдвэрлэлтийн хэмжээнд нөлөө үзүүлдэг.

Ноосон бүтээгдэхүүний гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох угаасан ноос 2021 онд 2.8 мянган тонн болж, өмнөх оноос 1.3 мянган тонн буюу 83.6 хувиар, эсгий 171.3 мянган метр болж 70.8 мянган метр буюу 70.4 хувиар, самнасан хонины ноос 300.5 тонн болж 217.3 тонн буюу 3.6 дахин, хивс 379.3 мянган м2 болж 17.8 мянган м2 буюу 4.9 хувиар, тэмээний ноосон хөнжил 19.7 мянган метр болж 1.9 мянган метр буюу 10.5 хувиар өссөн байна. Ноосон нэхмэл 47.4 тонн болж 202.8 тонн буюу 5.3 дахин буурсан байна.

Хүснэгт 11.1. Ноос боловсруулах салбарын үйлдвэрлэл

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020*	2021
Угаасан ноос /мян.т/	2.3	1.8	1.1	0.9	1.4	1.8	7.	8.7	3.3	3.4	1.5	2.8
Самнасан хонины ноос /тн/	-	-	-	72.6	168.8	61.8	131.0	161.6	228.5	196.0	83.2	300.5
Ээрсэн утас /т/	90.2	10.	11.6	9.9	6.7	0.4	0.	2.	7.4	0.	0.	0.
Хивс /мян.м2/	609.6	850.8	915.8	852.9	743.6	680.1	439.1	497.9	528.2	478.3	361.4	379.3
Тэмээний ноосон хөнжил /мян.м/	15.3	25.8	8.2	14.7	18.5	23.	12.2	30.2	9.4	9.9	17.8	19.7
Эсгий /мян.м/	104.5	208.	219.4	142.	127.9	125.6	89.4	114.9	112.1	181.6	100.5	171.3
Эсгий гутал /мян.хос/	19.2	25.2	22.1	15.2	8.	12.	0.5	0.3	0.4	0.6	0.1	0.5

Сүлжмэл эдлэл /мян.ш/	731.1	757.9	795.1	932.8	954.4	829.3	812.5	1,008.4	1,461.3	1,729.6	1,360.9	523.9
Ноосон нэхмэл /т/	330.2	262.6	314.9	243.	322.4	399.5	391.7	534.1	606.6	527.	250.2	47.4

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn
https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Industry_2021.pdf&ln=Mn, 26х

Нэг хүнд ногдох угаасан ноосны үйлдвэрлэл 2021 онд 0.9 кг болж өмнөх оноос 0.4 кг буюу 80 хувиар өсөж, 2019 оноос 0.2 кг буюу 18.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 11.2. Ноос боловсруулах салбарын үйлдвэрлэл, (Үйлдвэрлэлийн мэдээгээр)

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ	
		Үйлдвэрлэлийн мэдээгээр	Статистик мэдээгээр
Хагас боловсруулсан			
Угаасан ноос	тн	2,137.4	2,800
Самнасан ноос	тн	378.7	300.5
Эцсийн бүтээгдэхүүн			
Хивс	мян.м²	384.6	379.3
Сүлжмэл	ш	42,877	523,900*
Сүлжмэл /оймс	мян.хос	1,120.0	
Ноосон даавуу	мян.м	15.0	
Ээрмэл	тн	17.8	0
Ноосон хөнжил	ш	13,785	19.7 мян.м
Ноосон дулаалга	мян.м²	68.2	
Ноосон эдлэл	ш	600	
Эсгий	мян.м²	1,580,3	171.3 мян.м
Эсгий шаахай	хос	28,728	
Эсгий гутал	хос	600	500
Эсгий гудас	ш	17,416	
Ноосон гар урлал	ш	8,930	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022, www.1212.mn
https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Industry_2021.pdf&ln=Mn, 26х
"Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 2022

11.1. Хонины ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Урамшууллын падаанаар бэлтгэсэн/

2021 онд ноосны боловсруулах салбарын үйлдвэрүүд урамшууллын падаанаар бэлтгэсэн 22,036.6 тн хонины ноосны:

1. 37.3% буюу 8,226.4 тн ноос хивс, нэхмэл, сүлжмэл, ноосон даавуу, ноосон оёмол, ээрмэл, ноосон дулаалга, ноосон эдлэл, ноосон гар урлал, эсгий, эсгий гутал, эсгий шаахай, эсгий эдлэлийн үйлдвэрлэлд зарцуулагдсан.
2. 28.5% буюу 6,286.7 тн ноос хялгасыг нь ялгасан ноос буюу самнасан ноосны болон угаасан ноосны үйлдвэрлэлд зарцуулагдсан.
3. Будаг битум тэмдэгтэй, хэт шарласан, норсон, шээгтэй ноос, хатуу зөөлөн даахь нь ангилан ялгах шатанд ялгагдаж нийт 1,454.3 тн ноос үйлдвэрлэлд ашиглагдахгүй технологийн хаягдал болсон нь бэлтгэсэн ноосны 6.6%-ийг эзэлж байна.
4. Бэлтгэсэн ноосны 24.3% буюу 5,352.0 тн ноос үйлдвэрлэлийн агуулахад хадгалагдаж байна.
5. Урамшуулын падаанаар бэлтгэсэн 177.7 тн ноос дотоодод үйлдвэрүүдийн хооронд худалдан авах, 539.5 тн ноос дотоодод үйлдвэрүүдийн хооронд худалдах замаар шилжсэн нь нийт бэлтгэсэн ноосны 3.3%-ийг эзлэж байна.

График 11.1. Хонины ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Урамшууллын падаанаар/



Эх сурвалж: "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 2022

Хүснэгт 11.3. Хонины ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, (Урамшууллын падаанаар бэлтгэсэн)

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн			Зарцуулсан түүхий ноос	
Нэр төрөл	**Хэмжих нэгж**	**Тоо хэмжээ**	**Хэмжих нэгж**	**Тоо хэмжээ**
Бэлэн бүтээгдэхүүн:				
Хивс	мян.м²	384.6	тн	1,179.0
Сүлжмэл	ш	42,877.0	тн	79.4
Сүлжмэл /оймс	мян.хос	1,120.0	тн	472.6
Ноосон даавуу	мян.м	15.0	тн	87.3
Ээрмэл	тн	17.8	тн	107.6
Ноосон хөнжил	ш	13,785.0	тн	61.1
Ноосон дулаалга	мян.м²	68.2	тн	167.4
Ноосон эдлэл	ш	600.0	тн	0.3
Эсгий	мян.м²	1,580,3	тн	5,956.5
Эсгий шаахай	хос	28,728.0	тн	20.2
Эсгий гутал	хос	600.0	тн	0.6
Эсгий гудас	ш	17,416.0	тн	83.0
Ноосон гар урлал	ш	8,930.0	тн	11.4
Нийт:			**тн**	**8,226.4**
Хагас боловсруулсан:				
Самнасан ноос	тн	378.7	тн	2,110.7
Угаасан ноос	тн	2,137.4	тн	4,176.0
Нийт:			**тн**	**6,286.7**
Боловсруулалтад ороогүй түүхий ноос:				
Агуулахын үлдэгдэл			тн	5,352.0
Худалдаж авсан			тн	177.7
Худалдсан			тн	539.5
Хаягдал ноос			тн	1,454.3
Нийт:			**тн**	**7,523.5**
НИЙТ ДҮН:			**тн**	**22,036.6**


Эх сурвалж: "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 2022

11.2. Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Урамшууллын падаанаар бэлтгэсэн/

2021 онд ноосны боловсруулах салбарын үйлдвэрүүд урамшууллын падаанаар бэлтгэсэн 848.7 тн тэмээний ноосны:

1. 17.5% буюу 148.1 тн ноос сүлжмэл, ээрмэл, ноосон хөнжил, ноосон эдлэлийн үйлдвэрлэлд зарцуулагдсан.
2. 52.8% буюу 448.5 тн ноос хялгасыг нь ялгасан ноос буюу самнасан ноосны үйлдвэрлэлд зарцуулагдсан.
3. Ангилан ялгах шатанд 77.4 тн ноос үйлдвэрлэлд ашиглагдахгүй технологийн хаягдал болсон нь нийт бэлтгэсэн ноосны 9.1%-ийг эзэлж байна.
4. Бэлтгэсэн ноосны 19.4% буюу 164.4 тн ноос үйлдвэрлэлийн агуулахад хадгалагдаж байна.
5. Урамшуулын падаанаар бэлтгэсэн 10.3 тн ноос дотоодод үйлдвэрүүдийн хооронд худалдах замаар шилжсэн нь нийт бэлтгэсэн ноосны 1.2%-ийг эзлэж байна.

График 11.2. Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Урамшууллын падаанаар/



Эх сурвалж: "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 2022

Хүснэгт 11.4. Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, (Урамшууллын падаанаар бэлтгэсэн)

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн			Зарцуулсан түүхий ноос	
Нэр төрөл	**Хэмжих нэгж**	**Тоо хэмжээ**	**Хэмжих нэгж**	**Тоо хэмжээ**
Бэлэн бүтээгдэхүүн:				
Нэхмэл	ш	2,842	тн	10.8
Сүлжмэл	ш	8,205	тн	1.6
Сүлжмэл /оймс	мян.хос	31.1	тн	37.8
Ээрмэл	тн	24.7	тн	59.2
Ноосон оёмол	ш	961	тн	0.6
Ноосон хөнжил	ш	4,564	тн	17.3
Ноосон эдлэл	ш	2,760	тн	20.8
Нийт:			**тн**	**148.1**
Хагас боловсруулсан:				
Самнасан ноос	тн	96.1	тн	300.7
Угаасан ноос	тн	84.6	тн	147.8
Нийт:			**тн**	**448.5**

Боловсруулалтад ороогүй түүхий ноос:				
Агуулахын үлдэгдэл	тн		тн	164.4
Худалдан авсан	тн		тн	-
Худалдсан	тн		тн	10.3
Хаягдал ноос	тн		тн	77.4
Нийт:				**252.1**
НИЙТ ДҮН:			**тн**	**848.7**

Эх сурвалж: "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 2022

12. НООСОН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЭКСПОРТ

Экспортын биет хэмжээг өмнөх онтой харьцуулахад хонины ноос 37.4 хувиар буурчээ. Бэлтгэсэн хонины ноосны 14.4 хувь буюу 5.3 мянган тонн угаасан ноос хэлбэрээр экспортод гаргасан байна.

Хүснэгт 12.1. Хонь, тэмээний ноосны 2021 оны экспорт, импорт мян.ам.доллар

Барааны код	Барааны нэр	Хэмжих нэгж	Экспорт				Импорт			
			2020 он		2021 он		2020 он		2021 он	
			Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
51 Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу										
5101	Сэмлээгүй эсвэл самнаагүй хонины ноос.	кг	8,510,378.2	8,983.2	5,331,565.4	5,369.9	174,934.8	444.9	302,600.1	352.6
51011100	Зүнгаатай, хяргасан ноос	кг	0	0	0	0	19,697.0	6.1	180,682.4	35.8
51021942	Тэмээний угаасан эр ноос		11,960.0	47.8	7,010.0	7.4	.0	.0	24,500.0	24.5
51021944	Тэмээний угаасан эм ноос		824,710.2	2,328.6	322,133.0	851.5	0	0	0	0
	Нийт дүн			**11,359.6**		**6,228.8**		**451.0**		**412.9**

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Гаалийн статистик 2021, https://gaali.mn/statistic/news/6260fefa35d25a6c7a0ce962

Бэлтгэсэн хонины ноос 2021 онд 36.8* мян.тонн байснаас 5.3 мян.тонныг экспортод гаргасан бол 483.3 тонн хонины ноосыг импортоор оруулж ирсэн байна.

2021 онд үндэсний үйлдвэрлэгчид хонь тэмээний ноосон 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортод гаргасан байна.

Хонь, тэмээний ноосон бүтээгдэхүүний экспортын гол худалдан авагч нь БНХАУ байна.

Хүснэгт 12.3. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын экспорт, мян.ам.доллар

Барааны код	Барааны нэр	Хэмжих нэгж	2021 он	
			Тоо	Үнэ
5101	**Хонины сэмлээгүй буюу самнаагүй ноос.**	**кг**	**5,331,565.40**	**5,369.9**
	Австри		65.00	0.2
	БНХАУ		5,239,675.50	5,326.3
	ОХУ		89,324.10	35.8
	ХБНГУ		2,500.80	7.6
5102	**Мал, амьтны сэмлээгүй буюу самнаагүй үс, хялгас**	**кг**	**9,315,525.40**	**276,423.4**
	Америкийн Нэгдсэн Улс		34.10	0.9
	БНХАУ		9,310,393.90	276,385.7
	Непал		30.00	1.6
	ХБНГУ		5,067.40	35.2
51021942	**Тэмээний угаасан эр ноос**	**кг**	**7,010.00**	**7.4**

	БНХАУ		7,000.00	7.0
	Непал		10.00	0.4
51021944	**Тэмээний угаасан эм ноос**	**кг**	**322,133.00**	**851.5**
	Америкийн Нэгдсэн Улс		7.60	0.1
	БНХАУ		317,058.00	816.2
	ХБНГУ		5,067.40	35.2
	ОХУ		31,958.80	12.7
51032022	**Тэмээний ноосны сэв хялгас ноолуурын агууламж нь 22 хувиас их**	**кг**	**5,778.20**	**2.3**
	ОХУ		5,778.20	2.3
51053911	**Тэмээний самнасан ноос**	**кг**	**55,876.85**	**946.8**
	Итали		54,919.15	935.8
	Непал		200.00	8.5
	ОХУ		757.70	2.5
63012020	**Тэмээний ноосон хөнжил**	**ш**	**603.00**	**20.6**
	Америкийн Нэгдсэн Улс		29.00	5.1
	БНСУ		2.00	0.1
	Израиль		40.00	1.5
	Казахстан		12.00	0.1
	ОХУ		383.00	6.5
	Польш		10.00	0.7
	Унгар Улс		95.00	4.7
	ХБНГУ		21.00	0.8
	Чех улс		3.00	0.0
	Швейцар		4.00	0.6
	Япон		4.00	0.4
	БҮГД			**283,621.9**

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Гаалийн статистик 2021, https://gaali.mn/statistic/news/6260fefa35d25a6c7a0ce962

2019 онд ноосон бүтээгдэхүүн үйлдрвэрлэлийн салбар 76,708.2 мянган ам долларын экспорт хийж байсан бол 2020 онд 14,414.3 мянган ам доллар, 2021 он 9,089.7 мян.ам.дол болж экспорт буурчээ. Энэ нь цар тахлаас болж дэлхийн зах зээл дээр ноосон түүхий эдийн үнэ буурсантай шууд холбоотой юм.

Импортын хувьд 2019 онд 9,767.8 мян.ам.долларын импорт хийж байсан бол 2020 онд 6,241.8 мян.ам.дол, 2021 онд 7,123.7 мян.ам.дол-ын импорт хийж өсөх хандлагатай байна.

Харин Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны үйлдвэрлэлийн мэдээгээр үндэсний үйлдвэрлэгчид 2021 онд хонь тэмээний ноосоор үйлдвэрлэсэн 9 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортод гаргасан байна.

Хүснэгт 12.4. Хонь, тэмээний ноосон бүтээгдэхүүний экспорт, (Үйлдвэрлэлийн мэдээгээр)

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн			**Зарцуулсан түүхий ноос**	
Нэр төрөл	**Хэмжих нэгж**	**Тоо хэмжээ**	**Хэмжих нэгж**	**Тоо хэмжээ**
Бэлэн бүтээгдэхүүн:				
Хивс	мян.м²	44.7	тн	223.1
Сүлжмэл /хонины ноосон	ш	27,850	тн	55.7
Сүлжмэл /тэмээний ноосон	ш	5,719	тн	1.1
Нэхмэл /тэмээний ноосон	ш	673	тн	0.4
Ноосон оймс-хонины	мян.хос	883.9	тн	381.2
Ноосон оймс-тэмээний	мян.хос	28.6	тн	6.9
Эсгий шаахай	хос	25,728	тн	18.7
Ноосон гар урлал	ш	7,930	тн	3,4
Нийт:			**тн**	**690.5**

Хагас боловсруулсан:				
Самнасан тэмээний ноос	тн	7.8	тн	19.5
Нийт:			**тн**	**19.5**

Эх сурвалж: "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 2022

Хүснэгт 12.5. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын экспорт, импорт, 2019-2021 он, мян.ам.доллар

Барааны код	Барааны нэр	Хэмжих нэгж	Экспорт						Импорт					
			2019 он		2020 он		2021 он		2019 он		2020 он		2021 он	
			Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
51 Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу														
5101	Сэмлээгүй эсвэл самнаагүй хонины ноос.	кг	14,757,700.8	20,352.4	8,510,378.2	8,983.2	5,331,565.4	5,369.9	713,256.0	1,622.6	174,934.8	444.9	302,600.1	352.6
51011100	Зунгаггүй, хярагсан ноос	кг			0	0	0	0	190,441.0	44.4	19,697.0	6.1	180,682.4	35.8
51021942	Тэмээний угаасан эр ноос		310,105.7	920.8	11,960.0	47.8	7,010.0	7.4			.0	.0	24,500.0	24.5
51021944	Тэмээний угаасан эм ноос		740,739.0	2,769.4	824,710.2	2,328.6	322,133.0	851.5			0	0	0	0
51052910	Ноосон топс	кг			11,646.2	54.7	.0	.0			9,868.0	27.3	.0	.0
5105	Мал амьтны самнасан үс, хялгас	кг	893,420.4	48,385.7	489,728.6	18,204.2			6,056.8	92.8	9,877.5	27.8		
51052910	Ноосон топс	кг	19,203.0	144.1	11,646.2	54.7			5,226.8	31.6	9,868.0	27.3		
5106	Хонины сэмэлсэн ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл (аппаратын).	кг	78,870.6	23.7	66,548.2	107.6	44,748.6	231.6	2,429.2	34.2	18,988.2	69.8	154.3	18.2
5107	Хонины самнасан ноосон, жижиглэн баглаагүй ээрмэл (камволь).	кг	6,495.6	665.2	27,916.5	369.1	3.6	.0	6,674.8	281.5	5,077.3	692.0	1,914.6	226.4
5108	Мал амьтны нарийн ширхэгт үс, ноосон ээрмэл (жижиглэн баглаагүй)	кг	6,014.2	667.9	9,866.9	792.7	7,050.3	529.3	15,571.5	2,222.2	12,332.8	1,732.2	11,736.1	1,485.9
5109	Мал амьтны нарийн ширхэгт үс, ноосон ээрмэл (жижиглэн багласан).	кг	3,400.3	135.8	3,239.5	211.8	6,960.2	495.8	3,205.0	28.0	275.4	5.3	2,690.9	456.7
5111	Мал амьтны нарийн ширхэгт сэмэлсэн үс, ноосон даавуу.	м2	282,709.8	1,073.5	139,208.9	568.1	115,559.1	401.2	515,198.1	2,668.3	191,478.3	1,421.9	90,530.5	885.0
5112	Мал амьтны нарийн ширхэгт самнасан үс, ноосон даавуу.	м2	5,034.5	302.3	2,054.7	120.7	882.7	45.7	53,005.9	184.2	5,210.9	75.1	27,101.9	272.4

	Нийт			**75,440.80**		**13,584.30**		**7,932.40**		**7,209.80**		**4,474.60**		**3,757.50**
56 Зулмал хөвөн, эсгий ба нэхээсгүй материал; өвөрмөц ээрмэл; олс, оосор, дээс, татлага ба тэдгээрээр хийсэн зүйлс														
5602	Эсгий.	м2	1,921.4	18.6	717.6	14.4	150.2	4.2	285,360.3	225.8	322,104.8	202.1	206,715.8	139.6
	Нийт			**18.6**		**14.4**		**4.2**		**225.8**		**202.1**		**139.6**
57 Хивс болон нэхмэл дэвсгэр.														
5701	Нэхмэл материалын зүймэл хивс	м2	8,108.9	223.6	184.0	.8	68.3	2.6	4,422.6	36.7	279.4	16.4	1,105.8	43.7
5702	Үслэг биш, хээгүй хивс буюу бусад нэхмэл дэвсгэрэн зүйлс ба даавуун хивс, гар хивс	м2	32,225.8	904.7	27,766.5	725.8	45,217.9	1,102.3	44,014.4	189.0	15,283.9	177.6	88,013.0	561.2
5703	Гогцоот нэхээстэй хивс ба бусад нэхмэл дэвсгэр.	м2	546.7	11.8	624.7	27.4	109.7	.7	388,618.4	1,999.5	235,917.5	1,329.0	498,886.6	2,496.0
5704	Эсгий хивс ба нэхмэл эсгий дэвсгэр.	м2	2,849.7	27.9	183.4	9.4	397.7	14.9	5,916.6	39.6	1,035.7	8.9	572.0	9.6
57041000	0,3 м2 -аас ихгүй талбайтай жижиг хивс	м2	414.5	10.3	.0	.0	336.5	12.0	628.0	2.8	521.9	4.8	570.0	9.5
5705	Бусад хивс ба дэвсгэр.	м2	149.7	2.3	6.0	.2	.0	.0	12,115.3	61.9	2,427.9	28.4	20,762.2	105.6
	Нийт			**1,180.6**		**763.60**		**1,132.50**		**2329.5**		**1,565.10**		**3,225.60**
63 Бусад нэхмэл бэлэн эдлэл; иж бүрдэл; хуучин хувцас ба хуучин нэхмэл эдлэл; хаягдал даавуу.														
63012020	Тэмээний ноосон хөнжил	ш	4,201.0	68.2	2,931.0	52.0	603.0	20.6	141.0	2.7	.0	.0	64.0	1.0
				68.2		**52.0**		**20.6**		**2.7**		**.0**		**1.0**
НИЙТ ДҮН				**76,708.20**		**14,414.30**		**9,089.70**		**9,767.80**		**6,241.80**		**7,123.70**

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Гаалийн статистик 2021, https://gaali.mn/statistic/news/6260fefa35d25a6c7a0ce962

БОЛОВСРУУЛСАН: Б.Эрхэмбаяр, ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн



© Энэхүү материалыг ХХААХҮЯ-ны тусгай зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр хувилан олшруулах, ашиглахыг хориглоно.